



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-11

1.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан сонсох	4-11
---	------

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 04 дүгээр сарын 29-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Энхнасан;

Чөлөөтэй: Ц.Баатархүү, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, Д.Үүрийнтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхтуяа, Б.Түвшин;

Тасалсан: Ж.Чинбүрэн.

Хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт байгаа Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд томилолттой байгаа тул хэлэлцэхийг хойшлуулав.

Нэг.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигч Б.Рагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх тайланг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений тавьсан асуултад нэр дэвшигч Б.Рагчаа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, О.Саранчулуун, Б.Бейсен, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Х.Болормаа: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигч Баяраагийн Рагчааг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Х.Болормаа, А.Ариунзаяа нарыг дэмжсэнээр тооцож, 76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны гишүүд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 28 минут үргэлжилж, 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 10 цаг 35 минут

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Болормаа: Сайн байцгаана уу? Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийнхээ ирцийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн, Жадамбаагийн Баясгалан гишүүн, Буланы Бейсен гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, мөн Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн байна аа.

Хүндэтгэн үзэх шалтгаантай буюу чөлөөтэй, гадаадад томилолттой гишүүд 10 гишүүн байна. Ингээд ирц 52.4 хувьтайгаар өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа би та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, ЭМД-ын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг хэлэлцэх гэсэн байгаа.

Энэ асуудал дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хойд бүсэд ажиллаж байгаа учраас хүсэлт гаргасан тул Улсын Их Хурлын даргын зөвлөлийн хуралдаанд санал гаргаж дараа 7 хоног хүртэл хойшлуулах шийдвэр гаргасан тул өнөөдрийн хуралдаанд хэлэлцэхгүй болсныг та бүх бүхэндээ мэдэгдье ээ.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

ЭМД-ын Үндэсний зөвлөлийн даатгуулагчид төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэнэ. Ажлын хэсгийн гишүүдийг тань танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүнд нэр дэвшигчээр Баяраагийн Рагчаа.

МҮЭХ-ны ЕНБД Буянжаргал гэсэн 2 ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрийг та бүхэндээ танилцууллаа.

ЭМД-ын Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх тайланг Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа гишүүн танилцуулна.

А.Ариунзаяа: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

ЭМД-ын тухай хуулийн 14/1 дүгээр зүйлийн 14/1, 3 дахь хэсэгт ЭМД-ын үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж 5 жилийн хугацаагаар томилж чөлөөлөх бөгөөд нэг удаа улираан томилж болно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129-өөс 131 дүгээр зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа сонсголыг даргалж Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Баярмаа, Баясгалан, Бейсен, Болормаа, Булгантуяа, Ганмаа, Ганхөлөг, Зулпхар, Идэрбат, Мөнхтуяа, Сарнай, Чинбүрэн, Энхнасан, Эрдэнэбат нарын гишүүд оролцлоо.

ЭМД-ын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд МҮЭХ-оос тус холбооны дэд ерөнхийлөгч Баяраагийн Рагчааг Улсын Их Хуралд санал болгосон.

2025 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8 дахь хэсэгт заасны дагуу ЭМД-ын Үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Хоролсүрэнг хуралдаанд оролцсон гишүүдийн 3/2 саналаар томилсон.

Хараат бус шинжээч нэр дэвшигчийн ирүүлсэн бичиг баримт, ганцаарчилсан ярилцлага хийсний үр дүнд нэр дэвшигч Рагчааг мэргэжлийн хувьд шалгуур хангахгүй ч мэдлэг, туршлага, ур чадвар, ёс зүйн хувьд шалгуур хангаж байгаа талаар дүгнэлтээ сонсголд танилцуулсан.

Нэр дэвшигчийн танилцуулгад шинжээчийн дүгнэлттэй холбогдуулан сонсголд оролцсон гишүүд болон урьдчилан асуулт асууж, үг хэлэхээр бүртгүүлсэн иргэдийн төлөөлөл асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор хуралдаанд оролцсон гишүүд хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар нэр дэвшигч Рагчааг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн дэмжсэн. Түүнчлэн нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулан нэр дэвшигч болон түүнийг санал болгосон этгээдэд хүргүүлсэн болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Болормаа: Ариунзаяа гишүүндээ баярлалаа.

Тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүн нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Үг хэлэх гишүүд байна уу? Өө асуулт байна уу? Уучлаарай. Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ ЭМД-ын санхүүжилтийн асуудал одоо энэ эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал болоод байна. Яагаад гэвэл Улаанбаатар хотын клиникийн том эмнэлгүүд, аймаг дүүргийнхнийг 20-оос 30 хувь, хувийн эмнэлгүүдэд ч гэсэн 50 хувь хассан асуудал гарсан. Энэтэй холбоотой эрүүл мэндийн тусламж үйлчилгээ цалгардах асуудал үүсээд байна. Гол нь түрүүн бас ярьсан. Би ЭМД-ын Үндсэн зөвлөлийн гаргасан шийдвэр нь ард түмэн рүү чиглэсэн ард түмний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудалд чиглэсэн биш төсөв хэмнэж яаж хөрвөх вэ гэдэг үүднээс тийм шийдвэр болсон болов уу гээд хараад байгаа. Энэтэй холбоотой жишээлбэл хурц, төлөвлөгөөт, архаг гээд хуваасан.

Энэ нь бас эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт ЭМД-ын юунд сөрөг нөлөө үзүүлэх талтай. Яагаад гэвэл хурц өвчин бол нэг их биш. Ер нь ЭМД-ын санхүүжилтийн ихэнх асуудал нь архаг өвчнөөрөө санхүүждэг. Яагаад гэвэл уушгины архаг дутагдал, зүрх судасны архаг дутагдал, харвалтын дараах асуудлууд байж байгаа. Гэтэл энэ асуудал дээр ингээд архан өвчнийг хассан нөгөө талаар 3 дугаар эмнэлгээс судалгаа авсан. Зарим геми бари өвчин ч юм уу түрүүн мэдээгүй болох, нөгөө талаар зарим хүнд хэлбэрийн өвчнүүдийг ингээд хассан асуудал эргээд юунд нь сөргөөр нөлөөлж байна.

Тийм учраас энийг одоо ЭМД-ын Үндэсний зөвлөлд харж үзэхгүй бол зуны цагт чинь хурц өвчин нэг их гарахгүй шүү дээ. Эмнэлгүүдээр хэвтэхгүй. Ихэнхдээ архаг өвчин хяналтад байгаа улсууд хэвтдэг. Тэгэхээр энэ санхүүжилт зуны 3 сард буурах асуудал байна. Хөдөөгийн эмнэлгүүд дээр чинь ийм асуудал байгаа. Арьс өнгө, сэтгэц халдвартын тасагт зуны цагт хүн хэвтдэггүй байсан.

Нөгөө талаар энэний ажилчид зуны цагт эрүүл мэндийн салбарын ихэнх ажилчид ээлжийн амралт авдаг. Гэтэл энд ажиллаж байгаа улсууд амралт авахаар оронд нь хүн авч ажиллуулаад төсөв хэмнэдэггүй тийм асуудал байгаа. Хэмнэх боломж их байгаа. Энэ талаар та ямар бодолтой байна?

Х.Болормаа: Нэр дэвшигч Рагчаа. 5 номерын микрофоныг өгье.

Б.Рагчаа: Бейсен гишүүний асуултад хариулъя.

Ер нь ЭМД-ын санхүүжилттэй холбоотой эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа энэ байгууллагад өнөөдрөөс тулгамдсан асуудал нэлээдгүй байна. Тэгээд Үндэсний зөвлөлийн гишүүн бол нэг номерт энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой энэ асуудал дээр би бол онцгой анхаарч ажиллана аа. Тэгээд ер нь бол дотор нь орж байж зарим асуудлыг бас хөндөж тавих нэлээдгүй юм байна гэж харсан. Тэгэхээр энэ асуудлыг миний хувьд бол албан ёсоор Үндэсний зөвлөлийн гишүүн болсны дараа бас энэ асуудлыг тавья гэж бодож байна. Тэгээд мэдээж мэргэжлийн хүн Бейсен гишүүн тэгээд мөн бусад Байнгын хорооны гишүүдтэйгээ энэ асуудал дээр нэлээдгүй хамтарч ажиллах, мэдээллээр хангах мөн даатгуулагчийг төлөөлж байгаа учраас энэ даатгуулагчийн нэг номерын эрх ашигтай холбоотой энэ асуудлыг бол хамгийн түрүүнд тавина л гэж бодож байна.

Х.Болормаа: Бейсен гишүүн тодруулга байна уу? Баярлалаа.

Тэгэхээр нэр дэвшигчдээс манай Байнгын хороодын гишүүд тайлантай холбоотой асуултыг асуух асуух ёстой гэдгийг энэ дашрамд хэлье.

Ингээд үг хэлэх гишүүн байна уу? 2 гишүүн байна. 3 гишүүнээр тасаллаа. Баясгалан гишүүн, Бейсен гишүүн, Саранчулуун гишүүнээр тасаллаа.

Ж.Баясгалан: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд 100 хувь дэмжээд ингэж итгэл хүлээлгэж байгаа. Тийм болохлоор яг энэ итгэлийг даагаад анх яг энд ярьж байсан шигээ хичээгээд ажиллаарай. Тэгээд би бол яг сүүлийн үед энэ маш олон эмнэлгүүдээр шатлалын өөр өөр шатлалын эмнэлгүүдээр орж уулзсан. Тэгээд энэ дээр гарч байгаа тэр асуудлуудыг ингэж сонор, чих сонор соргог байж хүлээж авч бай. Тэндээс мэдээ мэдээллийг сайн цуглуулаарай. Яагаад гэвэл энэ нэг л асуудал гарах гээд байгаа нь энэ оношны төрлөөр нь ингээд оруулчихаар одоо жишээ нь сахраар өвдсөн хүн энд өөрөө хамрагдахгүй болчихож байгаа юм. Тэгэнгүүт эмнэлгүүд маань үр дүнтэй ямар ч байсан зардалдаа тааруулаад ажиллахын тулд энэ өвчнөөр өвдсөн хүмүүсийг авахгүй байх. Энэ дээр эрх ашиг нь зөрчигдөх нэг асуудал гарч байгаа шүү.

Хоёрдугаарт гэвэл тэр байгууллагууд маань өөрсдөө одоо энэ хасагдсан төсөвтөө тааруулаад тэрэн дээрээ нэмж орлого олж цалингийн төсөв нь ч гэсэн хүрэхээ байчхаж байгаа юм. Яг энэ дээр цалин бол нийт зардлынх нь 80 хувь болчихдог тэд нарын. Тэгэхлээр цалиндаа хүрэхгүй учраас цалиндаа хүргэхийн тулд яаж байна вэ гэвэл даатгалд хамрагдаж байгаа чиглэлээрээ илүү их ороо нэмээд, эмчилгээгээ нэмээд хамрагдаагүй бусад бүх тэр өвчлөл магадгүй хүндрэх эрсдэлтэй.

Хоёрдугаарт гэвэл тэр хэмжээгээрээ далд дахиад эдийн засаг бий болж байгаа юм. Одоо сахраар яалт ч үгүй хүнд өвдчихсөн хүнийг нөгөөдүүл чинь аваад эмчлэхгүй байх тийм арга байхгүй. Өөр тангараг байгаа учраас өөр өвчин рүү шилжүүлээд тиймээ ингээд одоо нэг цаана нь дахиад л нэг тийм далд мафижсан юм болчих вий. Энэ дээр сайн анхаараарай. Ерөөсөө гол ялгаа бол тэрэн дээр л гарч ирж байна лээ шүү сая. Бүгдээрээ бид нар бол ашигтай ажиллахын тулд бид нар ямар ч байсан өвчтөнүүдээ эмчлэхийн тулд ийм ийм арга хэмжээ авна гэж байгаа нь нэг талдаа зөв боловч нөгөө тал нь ингээд л асуудал үүсгэх магадлалтай байгаа.

Тэгэхээр та энэ дээр эхнээсээ сайхан бурууд нүд хурц сайн ажиллаарай. Тэгээд танд амжилт хүсье. Баясгалан гишүүндээ баярлалаа.

Бейсен гишүүн үг хэлнэ. Нэр дэвшигч дэмжиж байгаа. Тэгэхдээ нэг хэд хэдэн асуудлыг бас санал болгоод хэлье гэж бодож байна. Ер нь Монгол Улсын иргэд маань эрүүл байж улс орноо хөгжүүлэх ёстой.

Тийм учраас эрүүл мэндийн салбарт онцгой анхаарахгүй бол ЭМД-ын одоогийн тэр худалдан авалтын юу байж байна. Нөгөө талаар бас зарим шалгуур үзүүлэлтүүд хөрсөнд буухгүй байна? Орон нутагтаа тохирсон юм биш. Сум, аймгийн түвшинд ч гэсэн хотын түвшинд яах вэ болж л байна. Гэтэл энэ хөдөөд хэрэгжихэд тун хэцүү. Тийм учраас энэ дээр анхаарахгүй бол болохгүй. Яг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ байж байгаа. Урьд нь эрүүл мэндийн сайд хүртэл энүүгээр огцорч байсан шүү дээ. Нийгмийн эрүүл мэндийн асуудал байж байгаа. Эмнэлгүүдийн анхан шатын тусламж үйлчилгээний асуудал өрхийн эмнэлгийн асуудал байж байна. Нөгөө талаар эмийн тендерийн асуудал байж байна. Хөнгөлөлттэй эмийн асуудлууд байж байна.

Зарим хавдартай улсуудад хөнгөлөлттэй эм авч чадахгүй байна. Өндөр үнэтэй. ЭМД-ын тэр хөнгөлөлттэй эмийн жагсаалтад ордоггүй. Энийг бас нарийн заримыг нь мэргэжлийн эмч нараас асууж байж оруулахгүй бол болохгүй асуудлууд байж байгаа. Гол нь энэ ЭМД дампуурах шатандаа хүрээд байна л даа. Гэтэл гүйцэтгэлийн сангийн үзүүлэлт гэдэг нэрийн дор Эрүүл мэндийн сайд орон тоо, бүтцээ өөрсдөө мэд гээд ярьж байгаа.

Энийг ер нь ЭМЯ манай Нийгмийн бодлогын байнгын хороо ЭМД-ын ерөнхий газар хамтарч ер нь аймаг, сумын эмнэлгүүдийн яг орондоо захирагдсан бүтэц орон тоо батлахгүй бол ихэнх төсөв илүү орон тоо тэгээд НДШ-д явчхаад байна. Энэ дээр онцгой анхаарахгүй бол жишээлбэл нэг аймагт 386 орон тоо баталж өгчхөөд 505 орон тоогоор ажиллаж байгаа нөгөө талаар эмнэлгүүдийн удирдлагуудын асуудал байж байна. Мэргэжлийн бус хүн удирддаг. Клиникийн хувь дээрээсээ эмнэл зүйн хяналт хийж чаддаггүй гэх мэт. Эмийн тендер дээр бас нотой асуудал их гардаг.

Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна. Эмнэлгүүдийн ачаалал их байна. Хөдөө аймгийн төв, хотын эмнэлгүүд маш их ачаалалтай, сумын эмнэлгүүд байж байдаг. Санхүүжилт нь бас ингээд тодорхойгүй.

Тийм учраас энэ сая би хэлсэн улирлын чанартай энэ ЭМД-ын Үндэсний зөвлөл хатуу нэг юм баталчхаад тэгэхгүйгээр улирлын чанартай явал зохион байгуулаад даатгалын асуудлыг шийдэхгүй бол ерөөсөө болохгүй. Төсөв хэмнэх боломж их байгаа эрүүл мэндийн салбарын. Сая эмийг нь Чинбүрэн гишүүн ярьж байна лээ. Эмийг одоо ингээд худалдан авалт дээр нь сайд оролцсон гээд. Энийг бид нар тодорхой мэдэхгүй байна. Гэхдээ энэ асуудал дээр Онцгой ЭМД-ын ерөнхий газар онцгой анхаараад ажиллаад яг Монгол Улсын хөрсөнд буусан аймаг, сумын түвшин дэх нөгөө талаар өрхийн эмнэлэг, дүүргийн эмнэлэгт тохирсон юм хийхгүй бол хотын эмнэлгүүдийн санхүүжилт нь буурчихсан энэ чинь цаана чинь нормоор юм өгч байгаа биш өвчлөл гарлаа гэхэд ачаалал нь ихэснэ шүү дээ энэ чинь төсөв нь хүрэхгүй ийм асуудлууд ярьж байгаа.

Тийм учраас энэ дээр ЭМД-ын Үндэсний зөвлөлийнхөн бас энэ дээр анхаараад яг.

Х.Болормаа: Бейсен гишүүндээ баярлалаа.

Саранчулуун гишүүн үг хэлнэ.

О.Саранчулуун: ЭМД-ын зөвлөлд дахин дахин ярьж байгаа хэдэн асуудал л байгаа. ЭМД-аар санхүүжүүлж буй сувилал, уламжлалт болон сэргээн засах тусламж үйлчилгээний үнэлгээ уялдаа холбоог ялгаж салгамаар байна аа. Нийгмийн эрүүл мэндийн сургууль дээр 6 төрлийн мэргэжлээр сурч байна. Бусад сургууль ч гэсэн сурч байна. Энийгээ цэгцэлмээр байна 1 дүгээр асуудал. Энэ дээр ингээд анхаараад өгөөч, ажиллаад өгөөч гэж би хэлээд байгаа.

Хоёрдугаарх нь ЭМД-ын үйлчилгээ өөрөө эрүүл мэнд даатгалын үйлчилгээ чинь өөрөө нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөртэйгөө уялдуулсан ийм болмоор байна. Яагаад гэхээр нийгмийн эрүүл мэнд бол манайх одоогоор яах вэ урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ гээд явж байгаа. Халдварт өвчин н хяналт тандалт болж байна.

Халдварт бус өвчний менежмент гэхээрээ л одоо тэгээд л нөгөө л том хагалгаа, нөгөө л том эмчилгээ рүү яваад байгаа юм. Нэг өвчин тусаад 2 дахь эрсдэл бий болдог дээр ерөөсөө анхаарахгүй байна шүү дээ. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсний дараах үйлчилгээ хаачих юм бэ? Эмнэлгээс гараад хүн хаашаа явах вэ? Хагалгааны дараа яах вэ? Хавдрын дараа хүн хаачих вэ? Сахартай болсны дараа хаачих вэ гэдэг тэр залгамж холбоо нь 2 дахь урьдчилсан сэргийлэлт мөн шүү дээ. Тэрийгээ цэгцэлмээр байна аа.

Дараа нь нийгмийн эрүүл мэндийн энэ хөтөлбөр, нийгмийн эрүүл мэндээ сайжруулахын тулд нийгмийн эрүүл мэндийнхээ асуудал руу орсон санхүүжилтийн тэр нэг балансыг нь жоохон цэгцэлж ажиллах хэрэгтэй байна. Өнөөдөр та нар хараарай фэйсбүүкээр дүүрэн өвчтэй хүмүүсийн групп байгаа. Тэр группүүд дээр энэ эмийг уувал яадаг вэ? Хагалгааны дараа яадаг вэ? Хаана нь очих вэ гээд ингээд сэргээн засах, нөхөн сэргээх тусламж хайсан, сэтгэл зүйч хайсан, нийгмийн ажилтан хайсан, эсвэл тэр үйлчилгээг нь мэдэхгүй хүмүүсээр дүүрэн байгаа шүү дээ. Тэрэн дээрээ энэ ЭМД-аа уялдуулсан ийм эмнэлэг дээр суурилсан ийм юм хиймээр байна. Энэ дээр анхаарч авч үзээч ээ.

Дараагийнх нь болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан ЭМД-аас эм байгаа, протез байгаа, ортопед байгаа. Группт орсны дараах группийн мэдээллүүдийг авч байна. Группт оруулж байна гэж авчраад тэгээд баахан үзлэг хийххээд тэр мэдээллээ эргэж ашигладаг болмоор байна. Энийг бүүр хатуу анхаараад өгөөч ээ.

Дараа нь тэрэн дээр нь суурилаад үнэхээр тэр үзүүлж байгаа бол үзүүлсэн шиг үзүүлдэг болгомоор байна. Энэ дээр анхаараад өгөөч ээ. Хэрвээ бид нар энэ групп дээр үзүүлдэгээ ай си эф рүү шилжүүлэх юм бол хэнд ямар эрүүл мэндийн үйлчилгээ байх юм бэ гэдгээ бид нар ойлгоно шүү дээ. Тэгэхгүй ингээд нэг юм ёс төдий группийг нь сунгаж байгаа гэдгээрээ хүмүүсийг авчирч холоос янз бүрийн бэрхшээлтэй хүмүүсийг авчирснаа үзчихээд буцаагаад тэр үзлэг дээр нь тулгуурласан арга хэмжээ юу ч авахгүй болохоор чинь энэ надад ямар үйлчилгээ хэрэгтэй гэдгээ мэдэхгүй би юунаас хоцров? Юуг алдаж вэ гэдгээ ч мэдэхгүй хүмүүс тэгээд хаачих юм бэ? Энэ чинь эрүүл мэндийн үйлчилгээ чинь өвдөж зовсон хүмүүст л зориулсан үйлчилгээ биз дээ. Тэгэхээр энэ дээр анхаараач. Тэр ай си эф рүү яагаад ЭМЯ, ЭМД зэрэг газрууд анхаарлаа хандуулахгүй байгаа юм бэ? Энэ дээрээ анхаарч бүүр ажлын хэсэг үүсэж ингэж ажилламаар байна. Тэгэхгүй бол энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ ингээд л одоо энд сууж байгаа Баясгалан гишүүн бид 2 нэг ангил шүү дээ. Тулгуур эрхтний бэрхшээлтэй. Дотроо өөр өөр хэрэгцээтэй.

Тэгэхээр хүн болгонд өөрт нь тохирсон хэрэгцээ эрүүл мэндийн ялгаатай байдал байсаар байхад энийгээ ялгаж салгадаг тогтолцоо руу шилжихгүй бол яаж дараагийн шатанд явах юм. Ийшээгээ хувь нэмэр оруулахгүй бол халамжийн мөнгөө ярьсаар л байх болно шүү дээ. Ажил хийж чадахгүй, бие дааж чадахгүй. Тэгэхээр энэ дээрээ анхаарч ажиллаач гэдгийг бүр энэ ЭМД-ын зөвлөл, ЭМД-ын зөвлөлд нэр дэвшиж байгаа энэ хүнд бүр онцгойлон анхааруулж хэлье ээ. Баярлалаа.

Х.Болормаа: Саранчулуун гишүүндээ баярлалаа. Эрдэнэбат гишүүн үг хэлье.

С.Эрдэнэбат: ЭМД-ын үндэсний зөвлөлд нэг жил гаруй би томилогдоод нэг жил орчим ажиллаж байсан. Нэгдүгээрт бол гаргасан хууль тогтоомж шийдвэрээ гаргахаасаа өмнө бол яг бодит байдал дээр явж танилцах нь маш их чухал юм байна лээ шүү. Энэ тал дээр илүү их санаачилга гаргаад өшөө илүү ажиллаарай. Эмнэлгийн эмнэлгүүдийн санхүүжилтийн асуудал дээр нэлээн давхар цааш нь нэг давж харах хэрэгтэй юм байна лээ гэж би бодсон. Би бол өөрөө нэхээд бараагүй л дээ. Үндсэндээ энэ хэд хэдэн эмнэлгүүдээс санхүүжилтийг нь ингээд тодорхой хэмжээгээр нарийвчилж өгөөч, зардал дээр нь хяналт хийе. Зарим эмнэлгийн бас удирдлага, менежментийн хамт олон үнэхээр тэр санхүүгийн чиглэлээрээ мэдлэг боловсрол юу нь дутдаг юм шиг байгаа юм. Хүн удирдана, санхүү удирдана. Сайн эмч нар байдаг, эмнэлгийн дарга нар.

Тэгээд сайн менежерүүдийг сургаж дэмжих энэ тал дээр бол анхаарахгүй бол энэ гүйцэтгэлийн санхүүжилт үндсэндээ зардлаа дийлэхгүй байгаа. Цаашдаа яг энэ байдлаараа явах юм бол энэ санхүүжилтийг хэдэн төгрөгөөр ч нэмсэн дийлэхгүй.

Тийм учраас хамгийн оновчтой гэсэн эмчилгээ үйлчилгээнийх нь тэр хүртээмжүүдийг бид нар юуг нь санхүүжүүлэх вэ, юуг нь хамтын төлбөртэй байх вэ юуг нь огт санхүүжүүлэхгүй байх вэ гэдэг дээрээ зардлаа маш сайн хуваарилахгүй бол энэ нэлээн хүндрэлтэй байдал руу цаашид аваачна аа. Нэг зүйлийг тодруулж хэлмээр байна. Бид нар өнгөрсөн төсвөөр ЭМД-ын санг л 300 тэрбум төгрөгөөр бас эд нар нэмж өгсөн. Тэгээд эргээд ингээд эмнэлгүүдээс буцаагаад хасчихсан гэдэг юм яриад байх юм. Тэгэхээр энэ тал дээр ер нь ЭМД-ын Үндэсний зөвлөлийнхөн зардал хуваарилах дээрээ тэр эмнэлгүүдээ тойруулж суулгаж байгаад нэг, нэгээр нь тавиад тодорхой ярихгүй болохоор эмнэлгийн дарга нь удирдлагуудтай уулзахад нэг юм ярина. Даатгал нь нэг юм ярина. Иргэд нэг өөр юм ярина. Ажилчид өөр юм ярина. Тэгээд ийм 4 тал болчихоод хоорондоо үндсэндээ болж бүтэхгүй юмаа л ингээд л тойрч ярьдаг. Тийм учраас бол дараагийн ээлжид хэрвээ Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдож ажилласан тохиолдолд тэр эмнэлгүүдийн санхүүжилтээр бол ширхэгчлэн үзээрэй. Би үзүүлэхгүй байгаагийн цаана тод зарим эмнэлгүүдэд шүү. Асуудал байгаа юм болов уу гэдэг байдлаар хараад байгаа юм.

Хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настай, хэвтрийн хүнд өвчтөн, хөнгөвчлөх үйлчилгээний заалттай одоо энэ хүмүүст тэр үзүүлэх тусламж үйлчилгээг ялангуяа гэрээр болон өрхийн эмнэлгүүдийг тэр хүмүүст илүү хүрч ажилласан гэдгээр нь илүү урамшуулж дүгнэхгүй бол үндсэндээ эрүүл мэндийн үйлчилгээ авч чаддаггүй хөөрхий. Ар гэрт нь асар их санхүүгийн болон сэтгэл санаа давхар нэг хүн ажилгүй байдаг ийм хүмүүс маш их байгаа.

Тийм учраас цаашдаа энэ асрахуйн болон хэвтрийн ийм хүнд өвчтэй хүмүүсийг асарч дэмжих эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хууль эрх зүйн хувьд даатгалын шинэчлэлийг хийх шаардлагатай. Тодорхой хэмжээгээр даатгал оролцож байж л хийхгүй бол энэ хүмүүст одоо үндсэндээ маш ийм хүнд байдалтай байдаг учраас энэ сегментчлэл дээр нь онцгой анхаарал хандуулаарай гэдгийг хэлмээр байна. Мөн эмнэлгүүдэд харж байхад засвар үйлчилгээ үнэтэй томоохон тоног төхөөрөмжүүд рүүгээ анхаараад даатгалын мөнгийг тийшээ 1 дүгээрт зарцуулах мөнгө биш шүү. Энийг Сангийн яамтай маш сайн тохирч ажиллахгүй бол үндсэндээ төсвөөс гарч байх ёстой зардлуудыг даатгалын мөнгөнөөс гаргаад, яг даатгалын эм тариа, ажилчдын цалин хөлс, орлогод өгөх мөнгөнүүдийг ингээд хүрэлцэхгүй байна гэдэг ийм асуудал руу түлхээд байгаа учраас энэ тал дээр анхаараарай гэдгийг би хэлмээр байна.

Дараагийн ээлжид энэ Нийгмийн бодлогынхоо байнгын хорооны гишүүдтэйгээ сайн хамтарч ажиллаарай. Бид нар мэдлэг мэргэжил арга зүй болон хууль эрх зүйн хувьд нь мэргэжлийн Байнгын хороо учраас Үндэсний зөвлөл үндсэндээ нэг даргыгаа харсан байдалтай ийм байдалтай ажиллаж болохгүй шүү. Өөрсдөө санаачилгатай яваад даатгуулагч нартай уулзаад санал хүсэлтийг нь аваад эмнэлгээр тойроод явах хэрэгтэй. Ширээний ард суучхаад зузаан зузаан цаасыг ойлгох ойлгохгүйгээр гар өргөдөг байдал эцэс болох ёстой шүү гэдгийг хэлмээр байна аа.

Х.Болормаа: Байнгын хорооны гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа. Баяраагийн Рагчааг ЭМД-ын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох тухай саналыг дэмжье.

Санал дэмжигдвэл Үндэсний зөвлөлийн гишүүн Эрдэнэбатыг чөлөөлсөнд тооцож санал хураалтыг явуулах учиртай. Ингээд санал хураалт явуулъя аа. Протоколд миний нэрийг дэмжсэнээр оруулахыг хүсье. Ингээд Баясгалан, Ариунзаяа гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэхийг хүсье.

Ингээд нийт 61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа уншиж танилцуулна.

ЭМД-ын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх тайланг хэлэлцэж дууслаа. Ирсэн гишүүд ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

11.03 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА